



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.12.25 № 3Т-1/171

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Тогтоолын төсөл өргөн  
мэдүүлэх тухай

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

П.ОЮУН-ЭРДЭНЭ



000244008438



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БААСАНДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.12.25 № ХЭГ/2685  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт <sup>27</sup> ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ




000245026268

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦЭН нь: “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.12.25 № 01/10645  
танай 2024.12.25 -ны № 125/2682 -т

## МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Танаас ирүүлсэн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн зөвшөөрөл хүсэх тухай ХЭГ/2682 тоот албан бичигтэй танилцаад Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7-д заасны дагуу Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761003565



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 12. 25 № 1/2566

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлийн 19<sup>1</sup>.1 дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.



О.АЛТАНГЭРЭЛ

151605420  
А.Б.трайл.2024



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 12. 25 № 1/2585  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Ө.АЛТАНГЭРЭЛ

151605412  
A5.файл.2024

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН  
ТЭРГҮҮН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН  
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН  
САЙД

Л.ГАНТӨМӨР

БАТЛАВ.  
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

С.ОДОНТУЯА

СБТ-25822

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН  
САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

Н.ЧИРАЛ

БАТЛАВ.  
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТОО,  
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

БАТЛАВ.  
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

Ц.ТУВААН

## СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ОРЛУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Цэмийн энергийн тухай хуульд орсон 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөд “5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалzan Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.5.Энэ хуулийн 5.5-д заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.6.Энэ хуулийн 20<sup>1</sup>.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалzan Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэж тус тус заасан.

Энэ нь цацраг идэвхт ашигт малтмалыг хөрөнгө оруулагч талтай хамтран ашиглахдаа зөвхөн хувьцаа эзэмших замаар бус Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зарчмыг бусад хэлбэрээр хангуулах боломжийг бүрдүүлсэн байна.

### 1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан

бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн нэг нь тус хөтөлбөрийн 3.3.1.11-д “Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна.” гэж заасан Монгол, Францын хамтарсан Ураны төсөл юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг САС хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний протоколд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр талууд гарын үсэг зурсан.

“Зөөвч-Овоо” төслийг хэрэгжүүлэх хугацаанд “Бадрах энержи” ХХК-ийн 34 хувийн энгийн хувьцааны ногдол ашигт 2,151 сая ам.доллар, АМНАТ-д 717 сая ам.доллар буюу нийт улс, орон нутгийн төсөвт 5.6 тэрбум ам.доллар төвлөрөх тооцоолол гарсан. Харин 34 хувийн энгийн хувьцааг тус хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн тусгай АМНАТ-аар орлуулж, 14 хүртэлх хувийн суурь болон өсөн нэмэгдэх АМНАТ тооцоход давуу эрхийн хувьцаанд 593 сая ам.долларын ногдол ашиг, АМНАТ-д 2,007 сая ам.доллар (суурь АМНАТ-д 717 сая ам.доллар, тусгай АМНАТ-д 717 сая ам.доллар, өсөн нэмэгдэх АМНАТ-д 573 сая ам.доллар), нийт улс орон нутгийн төсөвт 5.2 тэрбум ам.доллар төвлөрөхөөр байна.

Хэдийгээр 34% энгийн хувьцааны хувилбарын тооцоолол нь илүү санхүүгийн өгөөжтэй мэт боловч Засгийн газар 34 хувийн хувьцаа эзэмших нөхцөлд төслийн хэрэгжилтийн явцад хөрөнгө оруулагч зардлыг удирдах, төслийг зээлээр санхүүжүүлэх зэрэг олон хэлбэрээр төслийн төлөх татвар хураамжийг бууруулах боломжтой байдаг тул Засгийн газар анх тооцож байсан ногдол ашгаа хүртэж чадахгүй, төслийн өгөөж тодорхойгүй хугацаагаар хойшлох эрсдэл байна.

Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын Засгийн газрыг дараа дараагийн төслүүдээ хөдөлгөхдөө жижиг хувьцаа эзэмшигчээр оролцохос зайлсхийж, төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр оролцох зөвлөмж болгосон байгааг<sup>1</sup> харгалзах нь зүйтэй байна.

Түүнчлэн, төслөөс улс, орон нутгийн төсөвт төвлөрөх татвар, төлбөр, хураамжийн орлого нь ногдол ашгийн орлоготой харьцуулбал төслийн зардлын өсөлтөд сул мэдрэг буюу эрсдэлгүй орлогод тооцогддог. Өөрөөр хэлбэл, Засгийн газар 34%-ийн энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Монголын талд ногдох нийт 5.6 тэрбум ам.долларын орлогын 82% нь зардлын өсөлтөд өртөмтгийг буюу эрсдэлтэй орлого, үлдсэн 18% нь зардлын өсөлтөөс үл хамаарах эрсдэлгүй, найдвартай орлого байна.

Харин Засгийн газар нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулснаар эрсдэлгүй орлогын хувийг 18%-аас 45% хүртэл өсгөх боломжтой болно.

Иймд 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, Монгол Улсын Засгийн газар ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжих эхэлсэн өдрөөс эхлэн төслийн үр өгөөжийг шууд хүртэх боломжийг бүрдүүлэх зорилгоор тогтоолын төслийг боловсруулна.

<sup>1</sup>The Role of the State in Mongolia's Mining Sector, 2021, World bank.

Дээрх хувилбарыг сонгосноор төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох тооцоолол гарсан бөгөөд үүнийг хөрөнгө оруулагчтай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд баталгаажуулан тусгахаар талууд тохиролцсон болно.

### **Хоёр.Тогтоолын төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Тогтоолын төсөлд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн олон улсын сайн туршлагыг харгалzan Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах MV-018915 дугаартай "Дулаан-Уул", MV-018916 дугаартай "Зөөвч-Овоо", MV-018914 дугаартай "Өмнөт" цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бадрах Энержи" ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалzan ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг тусгана.

Тогтоолын төсөл нь 3 заалттай байх бөгөөд 1 дүгээр заалтад "Бадрах Энержи" ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг, 2 дугаар заалтад ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тогтоох, 3 дугаар заалтад тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтооно.

### **Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Тогтоолын төсөл батлагдсанаар "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.1.11-д заасан Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаж, Монгол, Францын хамтарсан ураны төсөл үр ашигтай хэрэгжих боломж бүрдэнэ.

Түүнчлэн, төслийн хүрээнд 34 хувийн энгийн хувьцааг хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, 9 хүртэлх хувийн өсөн нэмэгдэх АМНАТ тооцож авах тохиолдолд давуу эрхийн хувьцаанд 593 сая ам.долларын ногдол ашиг, АМНАТ-д 2,007 сая ам.доллар нийт улс орон нутгийн төсөвт 5.1 тэрбум ам.доллар төвлөрөх боломжтой болно.

Мөн Монгол Улсын Засгийн газар ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн 19 хүртэлх хувийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцож, үр өгөөжөө шууд хүртэх боломжтой болно.

### **Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, Монгол Улсын нэгдэн орсон олон Улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу боловсруулна.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Цөмийн энергийн тухай хуульд орсон 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөд “5.5. Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалzan Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.5. Энэ хуулийн 5.5-д заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.6. Энэ хуулийн 20<sup>1</sup>.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалzan Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэж тус тус заасан.

Энэ нь Засгийн газраас цацраг идэвхт ашигт малтмалыг хөрөнгө оруулагч талтай хамтран ашиглахдаа зөвхөн хувьцаа эзэмших замаар бус Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зарчмыг бусад хэлбэрээр хангуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан 14 мега төслийн нэг болох Монгол, Францын хамтарсан ураны төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг судалж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах талаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл бэлтгэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг САС хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний протоколд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр талууд гарын үсэг зурсан.

“Зөөвч-Овоо” төслийг хэрэгжүүлэх хугацаанд “Бадрах энержи” ХХК-ийн 34 хувийн энгийн хувьцааны ногдол ашигт 2,151 сая ам.доллар, АМНАТ-д 717 сая ам.доллар буюу нийт улс, орон нутгийн төсөвт 5.6 тэрбум ам.доллар төвлөрөх тооцоолол гарсан. Харин 34 хувийн энгийн хувьцааг тус хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн тусгай АМНАТ-аар орлуулж, 14 хүртэлх хувийн суурь болон өсөн нэмэгдэх АМНАТ тооцоход давуу эрхийн хувьцаанд 593 сая ам.долларын ногдол ашиг, АМНАТ-д 2,007 сая ам.доллар (суурь АМНАТ-д 717 сая ам.доллар, тусгай АМНАТ-д 717 сая ам.доллар, өсөн нэмэгдэх АМНАТ-д 573 сая ам.доллар), нийт улс орон нутгийн төсөвт 5.2 тэрбум ам.доллар төвлөрөхөөр байна.

Хэдийгээр 34% энгийн хувьцааны хувилбарын тооцоолол нь илүү санхүүгийн өгөөжтэй мэт боловч Засгийн газар 34 хувийн хувьцаа эзэмших нөхцөлд төслийн хэрэгжилтийн явцад хөрөнгө оруулагч зардлыг удирдах, төслийг зээлээр санхүүгүүлэх зэрэг олон хэлбэрээр төслийн төлөх татвар хураамжийг бууруулах боломжтой байдаг тул Засгийн газар анх тооцож байсан ногдол ашгаа хүртэж чадахгүй, төслийн өгөөж тодорхойгүй хугацаагаар хойшлох эрсдэл байна. Дэлхийн банкны зүгээс хийсэн судалгаандаа Монгол Улсын Засгийн газрыг дараа дараагийн төслүүдээ хөдөлгөхдөө жижиг хувьцаа эзэмшигчээр оролцохос зайлсхийж, төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл АМНАТ-аар оролцохыг зөвлөмж болгосон байгааг<sup>2</sup> харгалзах нь зүйтэй байна.

Түүнчлэн, төслөөс улс, орон нутгийн төсөвт төвлөрөх татвар, төлбөр, хураамжийн орлого нь ногдол ашгийн орлоготой харьцуулбал төслийн зардлын өсөлтөд сүл мэдрэг буюу эрсдэлгүй орлогод тооцогддог. Өөрөөр хэлбэл, Засгийн газар 34%-ийн энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Монголын талд ногдох нийт 5.6 тэрбум ам.долларын орлогын 82% нь зардлын өсөлтөд өртөмтгий буюу эрсдэлтэй орлого, үлдсэн 18% нь зардлын өсөлтөөс үл хамаарах эрсдэлгүй, найдвартай орлого байна.

Харин Засгийн газар нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа, АМНАТ-аар орлуулснаар эрсдэлгүй орлогын хувийг 18%-аас 45% хүртэл өсгөх боломжтой болох юм.

Иймд 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, Монгол Улсын Засгийн газар ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжих өхэлсэн өдрөөс эхлэн төслийн үр өгөөжийг шууд хүртэх боломжийг бүрдүүлэх зорилгоор тогтоолын төслийг боловсрууллаа.

Дээрх хувилбарыг сонгосноор төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох тооцоолол гарсан бөгөөд үүнийг хөрөнгө оруулагчтай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд баталгаажуулан тусгахаар талууд тохиролцсон болно.

Тогтоолын төслийн 1 дүгээр заалтад “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг, 2 дугаар заалтад ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тогтоох, 3 дугаар заалтад тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан болно.

Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг ураны зах зээлийн үнийн түвшнээс хамаарч дараах байдлаар тогтоохоор заасан.

Ураны хүдрийн баяжмал (ураны исэл UЗO8)-ын зах зээлийн үнэ (ам.доллар/фунт)	Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ
0-40 хүртэл	0.0%
40-50 хүртэл	0.5%
50-аас дээш	5.0%

Тус тогтоолын төсөл батлагдсанаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.11-д заасан Зөөвч-Овоо, Дулаан

<sup>2</sup>The Role of the State in Mongolia's Mining Sector, 2021, World bank.

уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаж, Монгол, Францын хамтарсан Ураны төсөл үр ашигтай хэрэгжих боломж бүрдэнэ.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн танилцуулга болон улс орнуудын цацраг идэвхт ашигт малтмалын салбарт ногдуулах татварын харьцуулалтыг хавсаргав.

---оОо---

## ТАНИЛЦУУЛГА

“Бадрах энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч  
Орано Майнинг САС компанитай байгуулах  
Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Орано Майнинг САС компани хооронд байгуулах уран олборлох төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд санал, дүгнэлт боловсруулах, хэлэлцээ хийх, эцэслэн боловсруулсан хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 27 дугаар захирамжаар, тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх ажлын дэд хэсгүүд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 93 дугаар тушаал, 2024 оны 140 дүгээр тушаалаар тус тус байгуулагдан ажиллаж байна. Салбарын сайдуудаар ахлуулсан ажлын дэд хэсгүүд мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаач, хөндлөнгийн төлөөллийг оролцуулан өргөн бүрэлдэхүүнтэй байгуулагдаж энэхүү гэрээг Монгол улсын эрх ашигт нийцсэн, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа дийлэнх үр өгөөж ард түмэнд ногдож байх, талуудын хүртэх өгөөжийг тэнцвэртэй хангах суурь зарчмуудыг хатуу баримтлан ажилласан болно.

Мөн энэ чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий мэргэшсэн мэргэшсэн санхүү, хууль, байгаль орчны зөвлөхүүд (гэрээ, эрх зүйн чиглэлээр Английн White & Case олон улсын хуулийн фирмтэй 2024 оны 02 дугаар сарын 5-ны өдрөөс, татвар, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр АНУ-ын Charles River Associates олон улсын зөвлөх компанийтай 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс, байгаль орчны чиглэлээр ХБНГУ-ын GeoEnergy Consult компанийтай 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн)-ийг улсын аюулгүй байдлыг хариуцсан байгууллага (Тагнуулын ерөнхий газар)-тай зөвлөлдсөний үндсэн дээр авч ажиллуулсны дээр дотоодын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдийг ажиллуулж тэдгээрийн мэргэжлийн байр суурь, санал дүгнэлтийг гэрээнд тусгаж Монголын талаас гэрээний төслийн шинэчилсэн хувилбарыг боловсруулан хөрөнгө оруулагч талд хүргүүлсэн бөгөөд хөрөнгө оруулагчаас саналаа тусган ирүүлснийг ажлын хэсэг нарийвчлан судалж хэлэлцээг хийлээ. Ингэхдээ хэлэлцээрийг олон улсын жишиг арга аргачлал, нэгдэн орсон конвенц, гэрээ хэлэлцээг чухалчлан үзсэний дээр Монгол Улсын хууль тогтоомжид нийлүүлэхэд онцгой анхаарч олон талаас нь асуудалд дүн шинжилгээ хийж, ирээдүйд аливаа эрх зүйн үр дагаваргүй, жишиг гэрээ болон хэрэгжихэд анхаарч эдгээр ажлын хэсгүүдийн төлөөлөл нягт уялдаж ажилласан.

2023 оны 10 дугаар 12-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг САС компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээний протоколд талууд гарын үсэг зурсан бөгөөд протоколд тогтвортжуулалт, төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, ашигт малтмалын нөөц ашигласны суурь, өсөн нэмэгдэх, тусгай төлбөр, бүс нутгийн хөгжил, байгаль орчныг хамгаалах, хөрөнгө оруулалтын гэрээний урьдчилсан нөхцөлүүд зэрэг асуудлыг урьдчилан зөвшилцсөн байдал.

Энэхүү төсөл нь гуравдагч орны хоёр дахь томоохон хөрөнгө оруулалтын гэрээ болох бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх улс орон нутгийн төсөвт жилд 520 тэрбум, төслийн нийт хугацаанд 17,1 их наяд төгрөг, Үндэсний баялгийн санд жилд 61,5 тэрбум, төслийн нийт хугацаанд 2 их наяд төгрөгийг төвлөрүүлж валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, 1600 орчим ажлын байр

бий болгох ач холбогдолтойн дээр, шинэ технологи нутагшуулж, шинэ төрлийн үйлдвэр (хүхрийн хүчлийн үйлдвэр)-үүд баригдах боломжийг бүрдүүлэх юм.

Ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11, 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар тус тус өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хөрөнгө оруулалтын гэрээ, хэлэлцээний явцыг танилцуулж ажилласан. Улмаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагах хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг боловсронгуй болголоо.

Түүнчлэн ажлын хэсгийн өргөтгөсөн хурлыг хэд хэдэн удаа зохион байгуулж талуудын хооронд байгуулсан протокол, Цөмийн энергийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэлэлцээрийн бэлтгэлийг хангаж хөрөнгө оруулагчтай нийт 18 удаагийн хэлэлцээг хийж талуудын байр суурийг нэгтгэн шинэчилсэн гэрээний төслийг урьдчилан тохиролцод байна. Тус Хөрөнгө оруулалтын шинэчилсэн гэрээний төсөл нь 18 бүлэг 86 зүйл 355 заалттай бөгөөд Талууд хэлэлцээний үр дүнд дараах үндсэн нөхцөлүүдийг харилцан ойлголцлоо.

Үүнд:

Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

- Анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь ойролцоогоор 500,000,000 ам.доллар байх бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хийхээр тусгаж, хөрөнгө оруулагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой хугацаатай зааж өгсөн.
- Хөрөнгө оруулагч тал анхны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зээл, түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэхгүй өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тохирсон ба төслийн хугацаанд хувь нийлүүлэгчийн зээлийг хязгаарлаж, зээл авах зайлшгүй онцгой шаардлага үүссэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын 100% шийдвэрээр шийдвэрлэхээр тохирлоо. Энэ нь хөрөнгө оруулагч тал санхүүгийн үр ашигтай ажиллаж, ногдол ашгаараа хөрөнгө оруулалтаа нөхөх хөшүүргийг бүрдүүллээ.
- Засгийн газар төсөлд ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээхгүй байхаар тохирлоо.
- Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө Төсөл хэрэгжүүлэгч компанийд олгосон Хувьцаа эзэмшигчийн зээлийг Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэхээр тохирлоо.
- Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн санхүүгийн тооцооллыг шууд ашиглахаас илүүтэй, Техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан, олон улсын FAST (Flexible, Appropriate, Structured, Transparent) стандартын дагуу өөрийн талын санхүүгийн тооцооллын загварыг Монголын тал боловсруулж, хөрөнгө оруулагчтай тулган баталгаажуулалт хийсний үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийн дийлэнх хэсэг буюу 51-ээс доoshгүй хувийг Монгол Улс хуримтлагдсан дүнгээр жил бүр хүртэх тооцооллыг баталгаажууллаа.
- Гэрээний төсөлд Засгийн газрын үр өгөөжийг илүү хязгаарлагдмал хүрээнд тодорхойлж, хөрөнгө оруулагч талд ногдох үр өгөөжийг өргөн хүрээгээр тусгайлан дурдаж, хэрэв Монголын талын шууд үр өгөөж 51 хувьд хүрэхгүй тохиолдолд Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь хуримтлагдсан дүнгээр үр өгөөжийг 51 хувьд хүргэхэд шаардлагатай үр өгөөж

тохируулах нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй байхаар тохиролцлоо.

- Засгийн газар төсөл хэрэгжүүлэгч компанийн эздийн өмчийн 10 хувьтай тэнцэх “Төрийн эзэмшилийн давуу эрхийн хувьцаа”-г үнэ төлбөргүй, шууд эзэмших ба хувь хэмжээг буурахгүй, энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжинд ногдол ашиг хүртэх, давуу эрхийн хувьцааны ногдол ашиг хуваарилагдаагүй тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авахгүй байхаар тохирлоо.
- Засгийн газар нь бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг Хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа.
- Засгийн газар нь компанийн дүрэмд өөрчлөлт орох, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах болон хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардалд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар хориг тавих эрхтэй байх заалтыг тусгалаа.

Татвар, санхүүгийн чиглэлээр:

- Хөрөнгө оруулагч талаас нийт 12 төрлийн татварыг тогтвортжуулах саналыг ирүүлснийг хэлэлцээрийн явцад бууруулан, зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, АМНАТ, Гаалийн тариф гэсэн 4 төрлийн татварыг тогтвортжуулахаар тохирлоо.
- Татвар тооцох аргачлалыг өргөн утгаар нь тогтвортжуулах саналыг ирүүлснийг хэлэлцэн, зөвхөн татварын төрөл, хувь хэмжээ, элэгдэл, хорогдол тооцох хугацаа, алдагдал ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа гэсэн 3 үзүүлэлтийг тогтвортжуулахаар тохирлоо.
- АМНАТ-ийг үндсэн болон нэмэгдүүлсэн хувиар тооцох бөгөөд тусгай төлбөрийг бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс хасагдуулга, инфляци тооцохгүйгээр, бүрэн төлөхөөр тусгалаа.
- Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн (BEPS) эсрэг зарчим болон дотоодын хуулийг бүрэн дагаж мөрдөхөөр гэрээний төсөлд тусгав.
- Маркетингийн төлбөрийг татварын болон санхүүгийн тайлангийн зорилгоор хасагдах зардалд зардлаар бүртгэхгүй болохыг хэлэлцээрийн явцад хөрөнгө оруулагч талаар зөвшөөрүүлэв.
- Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн 286 дугаар тогтоолоос хойш өнөөг хүртэл шар нунтгийг ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнд тооцож экспортод “0” хувийн НӨАТ ногдуулан буцаан олгохоор заасныг өөрчлөхөөр хатуу байр суурийг баримтлан хэлэлцээр хийв. Хөрөнгө оруулагч талаас зөвхөн ураны төсөлд зориулж тогтоол өөрчлөхийг зөвшөөрөх боломжгүй гэсэн байр суурийг илэрхийлж байсан. Улмаар хэлэлцээрийн явцад Засгийн газар эцсийн бүтээгдэхүүнд “0” хувийн НӨАТ ногдуулах асуудлаар нэгдсэн бодлогоор бүх уул уухайн компанийд ижил хандсан тохиолдолд НӨАТ төлөхийг зөвшөөрөх боломжтой талаар хөрөнгө оруулагч талтай харилцан ойлголцолд хүрч гэрээний төсөлд тусгалаа.

Олборлолт, үйлдвэрлэл технологийн чиглэлээр:

- Бүтээгдэхүүнд агуулагдах бусад ашигт малтмалд АМНАТ тооцохоор тохирлоо.
- Хөрөнгө оруулалтын гэрээг төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж байгаа 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд авч үзэх, бусад ирээдүйд авч болох тусгай зөвшөөрлүүдийг хамруулахгүй байхаар тохирсон.
- Ордыг бүрэн ашиглах, үйлдвэрлэлийн хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, хэт бууруулах, нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг үндэслэлгүйгээр түр зогсоохоос сэргийлэх зохицуулалтыг тусгасан.

- Монгол Улс дотооддоо хүхрийн хүчил болон элементийн хүхэр үйлдвэрлэсэн тохиолдолд зах зээлийн бодит үнээр тэргүүн ээлжид худалдан авахаар тохирсон.
- Олборлолт, үйлдвэрлэл нь үндэсний лабораторийн хяналтад байх ба Олон улсын байгууллага (Олон улсын атомын энергийн агентлаг)-аар тогтмол аудит хийлгэх, гол түүхий эд болох хүхрийн хүчлийг дотоодын үйлдвэрээс хангах боломжийг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг тохирлоо.

Байгаль орчны хамгаалах чиглэлээр:

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдийн илэрхийлсэн байр суурь, гаргасан саналыг үндэслэн байгаль орчны салбарын албан татварыг тогтворжуулахгүй, Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөлийг тусгасан.
- Олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлж, байгаль орчны хяналт, мониторингийг гүйцэтгэхэд олон нийтийн оролцоог ханган, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа хангагдах шаардлагыг бүрдүүлэх;
- Усны нөөц, горим, чанарын төлөв байдлын өөрчлөлтөд байнгын ажиглалт, хяналт-шинжилгээ хийж, хяналт тавих;
- Энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын хуульд заасны дагуу ангилан ялгаж, дахин боловсруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Цацраг идэвхт хаягдлыг уурхайн талбайд ангилах, ялгах, боловсруулах, аюулгүй булшлах, эдгээр үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчныг нөхөн сэргээх асуудлыг бүрэн хариуцаж гүйцэтгэх;
- Мөн байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааг Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу байршуулах;
- Гурван жил тутамд төслийн үйл ажиллагаа болон технологидоо Олон улсын атомын энергийн агентлагийн шинжээчдээр хөндлөнгийн аудит хийлгэх;
- Техник, эдийн засгийн үндэслэл, Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглан Төслийн бүх үе шатанд байгаль орчны мониторинг, геоэкологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Төсөл хэрэгжүүлэгч компани нь байгаль орчин, усны хяналт мониторингийн үйл ажиллагаанд олон нийтийн төлөөллийн оролцоог хангахаар тус тус тохиролцлоо.

Бус, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр:

- Төсөл хэрэгжүүлэгч компани нь Дорноговь аймгийн Засаг дарга, Төсөл хэрэгжих Улаанбадрах сумын Засаг даргатай гурван талт хамтын ажиллагааны гэрээ байгуулж, орон нутгийн хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохирлоо.
- Төсөл хэрэгжүүлэгч хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Бүтээн байгуулалтын үе шатанд 300,000 ам.доллар, Уурхайн ашиглалтын үе шатанд 1,000,000 ам.доллар, Уурхайн хаалтын үе шатанд 1,100,000 ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ.
- Ажлын байрны сул орон тоо (удирдах албан тушаалыг оролцуулан)-д мэргэжлийн шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг тэргүүн ээлжинд

ажиллуулна. Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, хөлс, урамшуулал олгохоор тохирлоо.

- Уурхайн ашиглалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын 90 ба түүнээс дээш хувь нь Монгол Улсын иргэн байна. Төсөл хэрэгжүүлэгч компанийн авч ажиллуулах гадаад ажилтны тоо нийт ажилтны 10 хувиас хэтэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлнө. Бүтээн байгуулалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын хамгийн багадаа 60% нь Монгол Улсын иргэн байхаар тус тус тохирсон.
- Уурхайн ашиглалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компани нь төсөл дээр ажиллаж байгаа нийт Монгол ажилчдын 5 ба түүнээс дээш хувийг Дорноговь аймгийн, болон холбогдох сумын оршин суугч байх шаардлагыг хангаж ажиллана.
- Төсөл хэрэгжүүлэгч компани нь уурхайн ашиглалтын үе шатанд нийт туслан гүйцэтгэгчдийн 60%-аас доошгүй, жилийн нийт худалдан авалтын үнийн дүнгийн 40%-аас доошгүй нь Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээд байхаар тохирсон.

Гэрээ, эрх зүйн чиглэлээр:

- Хөрөнгө оруулалтын гэрээнд хууль тогтоомжийг тогтвортжуулахгүй бөгөөд зөвхөн хуульд орсон өөрчлөлт нь төслийн компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх буюу 5 жилийн хугацаанд хуульд орсон өөрчлөлт нь төсөл хэрэгжүүлэгч компанийн зардлыг 10 хувиар өсгөсөн тохиолдолд талууд хэлэлцээрт орохоор тусгалаа.
- Хөрөнгө оруулагчид өгч байгаа баталгаа, хамгаалалтын хүрээнд 1991 онд байгуулсан Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улсын хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээнээс давсан амлалт, баталгааг гэрээнд тусгахгүй байх үл ялгаварлах зарчмыг баримталсан.
- Хөрөнгө оруулалтын гэрээг 20 жилээр байгуулж, гэрээг тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд хуульд заасан хугацаагаар сунгаж байхаар гэрээнд тусгалаа.
- Хөрөнгө оруулагч гэрээнд заасан нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалт хийж төсөл хэрэгжүүлэх үүргээ зөрчсөн тохиолдолд Засгийн газар гэрээг цуцлах үндэслэл болж, хөрөнгө оруулагчийг үүрэгжүүлэхээр тусгалаа.
- Талуудын хооронд татварын маргаан үүсвэл дотоодын хууль тогтоомжийн дагуу маргаан шийдвэрлэх бүх процессыг дуустал олон улсын арбитрт хандах эрхгүй байхаар тохиролцлоо.

---оОо---

Хавсралт 2

**Улс орнуудын цацраг идэвхт ашигт малтмалын салбарт ногдуулах татварын хэмжээ**

№	Улс орнууд, нөөц	Уран олборлолт, тонн /2022 оны байдлаар/	ААНОАТ	АМНАТ, %	Өсөн нэмэгдэх АМНАТ, %	Хууль, тогтоомж
1	Казахстан 815,200 тн, нийт нөөцийн 13%	21,227 21,100 тн /2023 оны байдлаар/	20%	2023.01.01-ээс эхлэн 6%-иар тогтоосон. 2025.01.01-ээс эхлэн зөвхөн 2025 онд холбогдох хувь хэмжээ 9% хүртэл нэмэгдэнэ. 2026 оноос хойш төлөх татварын хувь хэмжээ опборгосон дунгээс хамаарна. 500 тн – 4% 1000 тн – 6% 2000 тн – 9% 3000 тн – 12% 4000 тн – 15% 4000-аас дээш – 18% байхаар Ерөнхийлгэчийн зарлиг гарсан.	Тайлант хугацаанд ИЭОв-ийн үнэ тодорхой босго хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд 2026 онос хойш татварын хувь хэмжээ нэмэгдэнэ. 70\$/фунт – 0.5% 80\$/фунт – 1% 90\$/фунт – 1.5% 100\$/фунт – 2% 110\$/фунт – 2.5%	Газрын баялаг ашиглах тухай хууль, Татварын тухай хууль
2	Канад 588,500 тн, нийт нөөцийн 10%	7,351	Улсын төсөөт -15%, орон нутгийн төсөөт 8-16%	Үндсэн металл, алмаз, уран зэрэг металл ашигт малтмал – Төлбөр төлхөөс өмнөх уурхайн нийт орлогын 1%, Төлбөр төлсний дараах уурхайн нийт орлогын 1%, цэвэр орлогын 12% байна.	Эрдээс баялатгийн татварын тухай хууль (1983), Орон нутгийн хууль болон борлуулалтын ашгаас хамаарна.	
3	Австрали 1,684,100 тн, нийт нөөцийн 28%	4,553	30% (Эргэлтийн хөрөнгө нь 50 сая австрали доллараас доош бол 25%-ийн	Уран - 3.75% Ашигт малтмалын нөөц ашиглах 5.5 % 7.5% Буталсан бүтээгдэхүүн бол 5% Баяжмайд	Татварын тухай хууль (Ашигт малтмалын нөөц ашигласны	

		татварын хөнгөлөлттэй)	2.5% металл, түүнтэй төстэй бүтээгдэхүчд, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд тонн тутамд тогтоосон үнээр тооцдог.	татвар), Уул уурхайн дурэм, журам (1981)
4	Нигер 311,100 тн, нийт нөөцийн 5%,	30% (25 сая нигерийн нариагийн орлоготой бол ААНОАТ-0%, 25-100 сая нигерийн нариа бол ААНОАТ-20%, түүнээс дээш бол том аж ахуй нэгж гэж үзэн 30%-ийн ААНОАТ ногдуулдаг)	Уран - 5,5% (Борлуулалтын ашгас хамаарч 12-15% болгохоор ажиллаж байна.)	Уул уурхайн тухай хууль (2006), борлуулалтын ашгаас хамаарч нэмэгдэнэ.
5	Намиби 470,100 тн, нийт нөөцийн 8%	Уул уурхайн компани болон уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг компани 2024-2025 онд ногдох ААНОАТ-37.5% (Алмазанд 55%)	Уран - 3%, борлуулалтын орлогогос хамааран ёсне.	Ашигт малтмалын нөөц ашиглласны төлбөрийг 1981 онд батлагдсан Эрдээс баялагийн хуулиар зохицуулдаг.
6	OXY 480,900 тн, нийт нөөцийн 8%	20% (Улсын төсөвт 2%, орон нутгийн төсөвт 18%)	/Зэс-8% Алт-6% Төмөр -4,8%/	Ашигт малтмалын нөөц ашиглласны төлбөр, татварын тухай дурэм, журам

7	Узбекстан 131,300 тн, нийт нөөцийн 2%	3,300	15% (ААНОАТ-ийн хувь хэмжээг Татварын тухай хуульд өмнө жил нь өрөнхийлөгчийн зарлигаар тогтоодог)	Уран-8% <i>/Байгалийн хий -10%, Алт-7% Зэс-7% Карбид-2.7% Нүүрс-4%/</i>
8	БНХАУ 223,900 нийт нөөцийн 4%	1,700	25% (ААНОАТ-ийн тухай хуулийн дагуу стандарт татварын хувь хэмжээ)	Уул Уурхайн хууль
9	АНУ 59,400 нийт нөөцийн 1%	75	21% (2017.12.22-нд батлагдсан АНУ-ын татварын шинэчлэгдсэн хуулиар “дэлхий даяарх- татварын тогтолцооноос “Нутаг дэвсгэр”-ийн татварын тогтолцоонд шилжиж, ААНОАТ- ын 35% хувь хэмжээг тогтмол 21% болгон бууруулсан)	Уул Уурхайн хууль 2017 он
10	Украин 107,200 нийт нөөцийн 2%	100	18% (ААНОАТ-ын стандарт 18%, 2024 оноос эхлэн банкуудын ААНОАТ- ийн хэмжээг 25%)	Уул Уурхайн хууль 2017 он


		хүртэл нэмэгдүүлсэн )			
11	Өмнөд Африк	27% (2023.03.31-ээс өмнө дуусгавар болох татварын жилүүдэд ААНОАТ- 28, 2023.03.31-нээс хойш дуусгавар болох татварын жилүүдэд 27% болсон. Алт олборлож буй компаниудад татварын тусгай хувь хэмжээг тогтоодог бол бусад ашигт малтамлд жирийн ААН-д ногдуулдаг татварыг ногдуулдаг)	Уран – Эхний 5 жилд 2%, Үүний дараа 5% (Боловсруулсан ашигт малтмалын АМНАТ 0.5-5%, Боловсруулаагүй ашигт малтмалын АМНАТ 0.5-7%)	Уул Уурхайн хууль 1971 он, Уул Уурхайн дүрэм журам 2011	
12	БНЭУ	200 320,900 нийт нөөцийн 5%	41.60-43.68% (Хуульд заасан гадны хэрөнгө оруулалттай ААН- ын суурь ААНОАТ- 40%, мөн 4% хүртэлх эрүүл мэнд, боловсролын татварыг нэмдэг )	Уран-6.6% (2021 онд АМИНАТ-ийг эхний 4 жилд дотоодын борлуулалтын 4%, экспортын 7%, дараагийн 3 жилд дотоодын борлуулалтын 3%, экспортын 6% байх ёстой гэж зохицуулсан.)	Ашигт малтмал, уул уурхайн хууль, 1957 он
13	БНЧУ	193 292,867 тн	21% (2024 оноос эхлэн ААНОАТ-21% болсон. Бүх ААН-д	Уран – 0.3% (АМИНАТ-ын 25%-ийг улсын төсөвт, 75%-ийг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг.)	Уул Уурхайн хууль, 1988 он 2006 онд шинэчлэгдсэн

			хамаарна. 2024 өмнөх нь 19%)		
14	Румын	50	Жижиг компани 60 мян.евро хүртэл-1%, 60 мян.евроос дээш-3%	16% Уран - 5% (Нийт үйлдвэрлэлийн үнийн дунгийн 5%)	Эрдэс баялагын нөөцийн үндэсний агентлаг
15	Пакистан	45	Жижиг компани 20% (Мэн нийт орлогын хэмжээнээс хамаарч супер татвар нэмж ногдуулдаг. Үүнд: (Пакистан рули) 150-200 сая - 1%, 200-250 сая – 2%, 250-300 сая – 3%, 300-350 сая – 4%, 350-400 сая – 6%, 450-500 сая – 8%, 500 саяас дээш – 10%).	29% Хөрөнгө оруулалт татаж байгаа тохиолдолд эхний 5 жилд АМНАТ-6.5%, 5 жилийн дараагаас аажмаар нэмэгдүүлнэ.	Татварын тухай хууль, Төлбөр хураамж, гаалийн тухай хууль
16	Бразил	43	ААН-ийн орлого жилд 240,000 бразил реалаас дэвсан бол 10%-ийн татвар нэмж ногдуулдаг.	15% Ашигт малтмал 1 – 3.5%	Уул Уурхайн тухай хууль (1967)
17	Иран	20	22.5% (ААНОАТ-ын стандарт хувь хэмжээ 25%)		

18	Малави 16,272 тн	0	35% (Уул Уурхайн төслөөс хүү, роялти, ногдол ашиг зэргээс олсон орлогын 10%-аар нэмж татвар төлне)	Уран – 5% (Австралийн Лотус компанитай 2024.08 сард байгуулсан улс ураны уурхай хөгжүүлэх гэрээнд Малави улс АМИНАТ- 5%, АДНОАТ-ыг 30% байхаар тогтоосон байна.)
19	ХБНГУ	0	30 – 33% (АМИНАТ болон ногдол ашигийг эх үүсвэрээс нь сүүтгэн авч татвар ногдуулдаг. Корпорацийн татвар 15%+5.5%, худалдааны татвар 8.75 – 20.3% гэсэн 2 татвар ногдуулдаг. Хотуудаас шалтгаалан өөр өөр)	Ашигт малтмал – 0-40% (Уурхайн талбайн км.квадрат тутамд 5 евро)
20	БНФУ	0	2020.01.01-ээс 31%, 2021.01.01-ээс 27.5%, 2022.01.01-ээс 25%	Татварын тухай хууль (7.63 сая еврогоос доош эргэлтийн хөрөнгөтэй бол эхний 38000 еврод 15%-ийн татварын хөнгөлөлт үзүүлнэ.
			Дундаж хэмжээ	27% 5%

<b>21</b>	<b>Монгол</b> Нийт нөөцийн 2%	192,241 ТН	10% эсвэл 25%	Нүүрс – 2.5% Алтнаас бусад – 5% /доод хэмжээ/ Ашигт малтмалын тухай хууль.
	<b>Нийт</b>	<b>49,355</b>		
	<b>Ураны исэл</b> (U <sub>3</sub> O <sub>8</sub> )	<b>58,201</b>		

Эх сургалж: <https://taxsummaries.pwc.com/france/corporate/taxes-on-corporate-income>

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай  
Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Цөмийн энергийн тухай хуульд орсон 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөд “5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалzan Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.5.Энэ хуулийн 5.5-д заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.” гэж, “20<sup>1</sup>.6.Энэ хуулийн 20<sup>1</sup>.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалzan Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэж тус тус заасан.

Энэ хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан Монгол, Францын хамтарсан ураны төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг судалж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах талаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл бэлтгэлээ.

Дээрх хувилбарыг сонгосноор төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох тооцоолол гарсан бөгөөд үүнийг хөрөнгө оруулагчтай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд баталгаажуулан тусгахаар талууд тохиролцсон болно.

Иймд тогтоолын төслийн 1 дүгээр заалтад “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг, 2 дугаар заалтад ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тогтоох, 3 дугаар заалтад тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тусгасан болно. Мөн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг ураны зах зээлийн үнийн түвшнээс хамаарч дараах байдлаар тогтоохоор заасан.

Ураны хүдрийн баяжмал (ураны исэл UЗO8)-ын зах зээлийн үнэ (ам.доллар/фунт)	Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ
0-40 хүртэл	0.0%
40-50 хүртэл	0.5%
50-аас дээш	5.0%

Тус тогтоолын төсөл батлагдсанаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.11-д заасан Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулагдаж, Монгол, Францын хамтарсан Ураны төсөл үр ашигтай хэрэгжих боломж бүрдэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

### СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ОРЛУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах MV-018915 дугаартай “Дулаан-Уул”, MV-018916 дугаартай “Зөөвч-Овоо”, MV-018914 дугаартай “Өмнөт” цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулахаар тус тус тогтсугай.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг хавсралтаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Төсөл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны  
... дугаар тогтоолын хавсралт

**АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ  
ТУСГАЙ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

Ураны хүдрийн баяжмал (ураны исэл U3O8)-ын зах зээлийн үнэ (ам.доллар/фунт)	Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ
0-40 хүртэл	0.0%
40-50 хүртэл	0.5%
50-аас дээш	5.0%